



ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ: МОНГОЛ УЛС АЗИ НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРТ НЭГДЭН ОРЛОО

Монгол улс удаан хугацааны хэлэлцээр хийж, дотоодын журмыг хангасны дараа 2020 оны 9 дүгээр сарын 29 өдөр Ази Номхон Далайн Худалдааны Хэлэлцээр (АНДХХ) –т нэгдэн орж, 7 дахь гишүүн орон боллоо¹. Монгол улс анх 2009 онд АНДХХ –т нэгдэн орох хүсэлтээ илэрхийлсэн байна². Тус хэлэлцээрт нэгдэн орохын тулд оролцогч талууд (Бангладеш, БНХАУ, Энэтхэг, Лаос, БНСУ, Шри Ланка) –тай цуврал хэлэлцээр хийж, мөн 2019 оны 12 дугаар сарын 12 –ны өдөр Монгол Улсын Их Хурал “Ази Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай” хуулийн төслийг соёрхон баталсан байна³. Энэхүү хэлэлцээр 2021 оны 1 дүгээр сарын 1 –нээс хэрэгжиж эхэлнэ.

АНДХХ (хуучнаар Бангкокийн Хэлэлцээр) нь бүс нутгийн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр бөгөөд бүс нутгийн худалдааг өргөжүүлж, тэдгээрийн эдийн засгийг хөхиүлэн дэмжих, худалдааг харилцан либералчлах, харилцан ашигтай хамтын ажиллагааг хангах зорилготой.

2019 онд Монгол улсын нийт экспортын 89.4% -ийг, импортын 38.7% -ийг гишүүн орнуудын экспорт, импорт эзэлж байжээ (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2020). Иймд, хэлэлцээрт нэгдэн орсноор гадаад худалдааны зах зээлийг тэлэх таатай орчин бий болох бөгөөд Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүн БНХАУ, БНСУ –ын зах зээлд дунджаар 40% -ийн хөнгөлөлт эдлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна⁴. Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад зааснаар Монгол улс 366 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн үүнд голдуу далайн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, амьтны болон ургамлын гаралтай тос, зарим ашигт малтмал, химийн бүтээгдэхүүн, мод, нэхмэлийн утас, химийн нийлэг, машин, тээврийн тоног төхөөрөмж зэрэгт гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлнэ. Үүнээс гаалийн нэн тааламжтай тарифын хэмжээ 5%, хөнгөлөлттэй тарифын хэмжээ 10 – 30% хүртэл байна⁵.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, GRATA International Хуулийн Фирмийн партнер В.Болормаа болон эрх зүйч Т.Буянжаргалмай bvolodya@gratanet.com, btungalag@gratanet.com эсхүл +976 70155031 утсаар холбогдоорой.

¹ <https://www.unescap.org/apta/tariff-concessions/mongolia-accession>

² <https://www.unescap.org/events/capacity-building-workshop-mongolia-how-utilize-opportunities-apta-membership>

³ <https://www.legalinfo.mn/law/details/14818?lawid=14818>

⁴ <https://www.legalinfo.mn/details/1280>

⁵ <https://www.unescap.org/sites/default/files/offerlist-Mongolia-Rec-on-23-oct%202018.pdf>